



**УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ТАМГЫН
ГАЗРЫН ДАРГА, МОНГОЛЫН ҮНДЭСНИЙ ХУДАЛДАА АЖ ҮЙЛДВЭРИЙН
ТАНХИМЫН ДЭРГЭДЭХ МОНГОЛЫН ОЛОН УЛСЫН АРБИТРЫН
ДАРГЫН ХАМТАРСАН ТУШААЛ**

2020 оны 04 сарын 09 өдөр

Дугаар 4-24/02

Улаанбаатар хот

Загвар батлах тухай


Монгол Улсын Их Хурлын Сонгуулийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.2.4, Монгол Улсын Шүүхийн Захиргааны тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.5, 22 дугаар зүйлийн 22.1.5, Арбитрын тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.1.2, Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимын Дэргэдэх Олон Улсын Арбитрын Төвийн Дүрмийн 2.4 дүгээр зүйлийн 2.4.2-т заасныг удирдлага болгон ТУШААХ НЬ:

1. Монгол Улсын Их Хурлын Сонгуулийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.2.4 дэх заалтын хэрэгжилтийг хангах зорилгоор Монгол Улсын Их Хурлын 2020 оны ээлжит сонгуульд нэр дэвшигчийн лавлагаа хүсэхэд бүрдүүлэх бичиг баримтын жагсаалтыг нэгдүгээр, уг жагсаалтад дурдсан нэр дэвшигчийн лавлагаа хүсэх тухай өргөдлийн загварын маягтыг хоёрдугаар, зээл, барьцаа болон батлан даалтын талаар шүүхэд хариуцагчаар татагдан оролцож байсан эсэх мэдээллийг мэдүүлэх загварын маягтыг гуравдугаар, Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимын дэргэдэх Монголын Олон Улсын Арбитраас авах лавлагааг хүсэх тухай өргөдлийн загварын маягтыг дөрөвдүгээр хавсралтаар тус тус баталсугай.

2. Хамтарсан тушаалын хүрээнд мэдээллийг шуурхай солилцож, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Улсын Дээд шүүхийн Иргэний хэргийн танхимын тэргүүний туслах-ахлах шинжээч Н.Мөнхтүлга, Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимын дэргэдэх Монголын Олон Улсын Арбитрын нарийн бичгийн дарга Б.Маралгуя нарт даалгасугай.

УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ТАМГЫН
ГАЗРЫН ДАРГА

Ж.НАРАННУРЭВ



МУХАУТ-ЫН ДЭРГЭДЭХ
ОЛОН УЛСЫН АРБИТРЫН
ДАРГА



С.ЭНХЦЭЦЭГ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2020 ОНЫ ЭЭЛЖИТ СОНГУУЛЬД НЭР ДЭВШИГЧИЙН ЛАВЛАГАА ХҮСЭХДЭЭ БҮРДҮҮЛЭХ БИЧИГ БАРИМТ

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.2.4, 29 дүгээр зүйлийн 29.3.1-д заасан лавлагааг 2020 оны 04 дүгээр сарын 28-ны өдрөөс эхлэн олгоно.

Лавлагaa хүсэхдээ дараах бичиг баримтыг бүрдүүлнэ.

Үүнд:

1.Иргэний үнэмлэхний хуулбар

2.Улсын Их Хурлын ээлжит сонгуульд нэр дэвшигчийн лавлагaa хүссэн өргөдөл.

/загвар №1/

3.Иргэний сүүлийн 10 жил байнга болон түр оршин суугаа газрын тодорхойлолт.

4.Банк, бусад хуулийн этгээд, иргэнд төлбөл зохих зээл, барьцаа батлан даалтын талаар Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд заасны дагуу шүүх, арбитрт хариуцагчаар татагдан шүүн таслах ажиллагаанд оролцож байсан эсэх мэдээлэл.

/загвар №2, 3/

Загвар №1

МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХЭД

2020 оны дугаар сарын өдөр

Улаанбаатар хот

Лавлагаа хүсэх тухай

..... овогтой миний бие Улсын Их
Хурлын 2020 оны ээлжит сонгуульд тойрот
..... /нам, эвсэл, бие даагч аль нь болох доогуур зурах/ нэр
дэвшиж, холбогдох баримт бичгийг хуулийн дагуу бүрдүүлсэн болно.

Иймд Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн
32.2.4-д заасан лавлагааг гаргаж өгнө үү.

Өргөдөл гаргасан: /

Загвар №2

ЗЭЭЛ, БАРЬЦАА, БАТЛАН ДААЛТЫН ТАЛААР ШҮҮХЭД ХАРИУЦАГЧААР
ТАТАГДАН ОРОЛЦОЖ БАЙСАН ЭСЭХ МЭДЭЭЛЭЛ

Банк, бусад хуулийн этгээд, иргэнд төлбөл зохих зээл, барьцаа батлан даалтын талаар Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд заасны дагуу хариуцагчаар татагдан шүүн таслах ажиллагаанд оролцож байсан эсэх талаарх нэр дэвшигч-ын мэдээлэл

1. Зээл, барьцаа, батлан даалтын үүрэгтэй холбоотой иргэний эрх зүйн маргаанд шүүхэд хариуцагчаар оролцож байсан эсэх

Тийм

Үгүй

Хэрэв тийм бол доорх хэсгийг бөглөнө үү?

2. Аль шүүхийн шүүн таслах ажиллагаанд хариуцагчаар татагдан оролцож байсан бэ?.....

3. Хэдэн онд

4. Тухайн маргаан эцэслэн шийдвэрлэгдсэн эсэх

Тийм

Үгүй

5. Тухайн хэргийг хянан шийдвэрлэсэн шүүхийн Шийдвэр, Магадлал, Тогтоолын огноо, дугаар

Тийм

Үгүй

6. Шүүхийн шийдвэр, магадлал, тогтоолыг албадан гүйцэтгүүлэхээр шүүгчийн захирамж гарсан эсэх

...../захирамжийн огноо, дугаар/

7. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа дууссан эсэх.

Тийм

Үгүй

Мэдээллийг үнэн зөв гаргасан : /

2020 оны 04 дүгээр сарын

Загвар №3

Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимиын дэргэдэх
МОНГОЛЫН ОЛОН УЛСЫН АРБИТРТ

2020 оны-р сарын-ны өдөр

Улаанбаатар хот

Улсын Их Хурлын 2020 оны сонгуульд нэр дэвшигч би,

Регистрийн дугаар:	_____
Ургийн овог:	_____
Эцэг / эхийн нэр:	_____
Өөрийн нэр:	_____

Монгол Улсын Их Хурлын Сонгуулийн тухай хуулийн 29 дүгээр зүйл “Нэр дэвшүүлэх нийтлэг журам”-ын 29.3.1 “Нэр дэвшигч банк, бусад хуулийн этгээд, иргэнд шүүх болон арбитрын шийдвэрээр тогтоогдсон төлбөл зохих зээл, барьцаа болон батлан даалтын өр төлбөргүй байх” гэх шаардлагыг хангаж байгаа эсэхийг тодорхойлох хүсэлтэй байх тул миний бие тус арбитраар тогтоогдсон төлбөл зохих зээл, барьцаа болон батлан даалтын өр төлбөртэй эсэх талаарх лавлагаа гаргаж өгнө үү.

Уг лавлагааны хувийг Улсын Дээд Шүүх, Сонгуулийн Ерөнхий Хороонд хүргүүлэхийг миний бие үүгээр зөвшөөрч байна.

ХҮСЭЛТ ГАРГАСАН

/......./